



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/214

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 3/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 35 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Вирусологийн лабораторид PCR шинжилгээ хийхэд шаардлагатай RNA ялгах китийг худалдан авахад шаардагдах 33300.0 мянган төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 33300.0 мянган төгрөг /гучин гурван сая гурван зуун мянган/-ийг аймгийн техник хяналтын зардлын данснаас дараа тооцоогоор зохицуулж санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Аймгийн техник хяналтын зардлаас дараа тооцоогоор санхүүжүүлсэн 33300.0 мянган төгрөгийг аймгийн 2021 оны төсөвт тухайн зардлын батлагдсан эх үүсвэрээс нөхөн тооцоо хийж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/214 Ch
02 1228

Аймгийн Засаг даргын 2021 оны 04
дүгээр сарын 27-ны өдрийн А/214
дүгээр захирамжийн хавсралт



ВИРУСОЛОГИЙН ЛАБОРАТОРИД PCR ШИНЖИЛГЭЭ ХИЙХЭД
ШААРДЛАГАТАЙ RNA ЯЛГАХ КИТИЙГ ХУДАЛДАН АВАХ ЗАРДАЛ

ДД	Байгууллагын нэр	Зориулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /мянган төгрөг/
1	Аймгийн БОЭТөв	Вирусологийн лабораторид PCR шинжилгээ хийхэд шаардлагатай RNA ялгах кит	ш	1850	18000.00	33300.0
	Дүн					33300.0

-oOo-